

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ГАНБАТЫН ЭНХТУЛГЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Гүйцэтгэлийн түвшин		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
		1	2	3	4	5	6
Зорилт 1. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бизнес процессын дахин инженерчлэл хийх							
1.	Арга хэмжээ 1.1. Яамны төлөвлөгөөний 40. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт боловсруулна.	Хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн тоо	-	2	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/55 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө дараах системүүдэд зөвлөмж, дүгнэлт боловсруулж хүргүүлсэн. Үүнд: 1. Гадаадын иргэнд оршин суух үнэмлэх хэвлэх киоск машины программ хангамжийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.01.03-ны өдөр 03/06 бичгээр Гадаадын иргэн, харьяатын газарт; 2. Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн “mpetro.smartsolution” системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.02.04-ний өдөр “isr.gov.mn” системээр Ашигт малтмал газрын тосны газарт; 3. Хууль зүйн туслалцааны төвийн хиймэл оюунд суурилсан хуулийн зөвлөгөө өгөх мобайл аппликэйшн хөгжүүлэх ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид	2025.01.01-2025.06.15	100%

					саналаа 2025.02.17-ны өдөр цахим шуудангаар нэгтгэсэн албан хаагчид; 4. Авто зогсоолын удирдлага, зохион байгуулалтын ухаалаг систем ба тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолттой танилцан, судлан үзэж, зөвлөмж бүхий хариуг 2025.02.18-ны өдөр 03/387 бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт; 5. Тээврийн хэрэгслийн нэгдсэн удирдлагын систем (VIMS)-ийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.02.26-ны өдөр 03/466 бичгээр Зам тээврийн яаманд; 6. Хүн амын өрхийн мэдээллийн сангийн мэдээллийн системийн /шинэчлэл/ ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.02.28-ны өдөр "isr.gov.mn" системээр Үндэсний статистикийн хороонд; 7. Хоригдогсдын бүртгэл, хяналтын системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.16-ны өдөр "isr.gov.mn" системээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт; 8. Түрээсийн орон сууцны цахим системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.17-ны өдөр "isr.gov.mn" системээр Төрийн орон сууцны корпорац ХХК-д; 9. Агуулахын бүртгэлийн системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.17-ны өдөр "isr.gov.mn" системээр Зоонозын өвчин судлалын үндэсний төвд.		
2.	Арга хэмжээ 1.2.	Боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	2025.01.01-2025.03.31	100%

	Яамны төлөвлөгөөний 45. “Цахим засаглалыг эрчимжүүлж, салбар бүрийн эрх зүйн орчны реформ хийх” үйлчилгээний ажлын даалгавар боловсруулж, батлуулна.				батлах тухай” А/01 дүгээр тушаалын хүрээнд “Цахим засаглалыг эрчимжүүлэх, салбар бүрийн эрх зүйн орчны реформ хийхэд хуулийн зөвлөх үйлчилгээ”-ний ажлын даалгаврыг боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан. Улмаар үнэлгээний хорооны тушаалын төслийг боловсруулан, Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар батлуулан ажлын даалгаврыг шилжүүлэн, хүлээлгэн өгсөн.		
Зорилт 2. Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах							
3.	Арга хэмжээ 2.1. Яамны төлөвлөгөөний 47. “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” /Цахим аймаг-Ухаалаг хот/ зөвлөмж боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Баримт бичгийн тоо	-	1	- Иргэдийн амьжиргаа, цаг хугацааг хэмнэх амьдрах таатай орчныг бүрдүүлэх “Дижитал-Аймаг, Дижитал-Хот” зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025.01.15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулсан. “Дижитал аймаг, Дижитал хот” /Цахим аймаг-Ухаалаг хот/ зөвлөмжийн төслийг боловсруулж, 2025.02 дугаар сард тус ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн, улмаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах материал, шийдвэрийг төслийг боловсруулж хяналтын шатанд шилжүүлсэн. - Мөн тус зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ЦХИХХСайд болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2025 онд хамтран ажиллах гэрээнд тусгах саналыг боловсруулж, 2025.01.07-ны өдөр	2025.01.01-2025.06.15	80%

					Төрийн захиргааны удирдлагын газарт цахим шуудангаар хүргүүлсэн.		
4.	Арга хэмжээ 2.2. Яамны төлөвлөгөөний 48. Төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбарыг бүртгэх, хадгалах системийг Үндэсний дата төвтэй хамтран нэвтрүүлнэ.	Нэвтрүүлсэн системийн тоо	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/01 дүгээр тушаалын хүрээнд “Төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбар бүртгэх, хадгалах систем нэвтрүүлэх” үйлчилгээний ажлын даалгаврыг төслийг бэлтгэх 2025.02.21-ний өдрийн 03/327 тоот бичгийг Үндэсний дата төв УТҮГ-т хүргүүлэн, хамтран боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан. Улмаар үнэлгээний хорооны тушаалын төслийг боловсруулан, Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар батлуулсан. Тус тушаалын дагуу үнэлгээний хороо ажиллаж, 2025.05.29-ний өдөр ЦХИХХЯ/20250103050 дугаартай худалдан авах ажиллагааг нээгээд байна.	2025.01.01-2025.06.15	70%
5.	Арга хэмжээ 2.3. Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай санал, хүсэлт, чиглэлийг холбогдох байгууллагад хүргүүлэх замаар хэрэгжилтийг хангуулна.	Хүргүүлсэн албан бичгийн тоо	-	5	Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай 18 чиглэлийг харьяа байгууллагад хүргүүлэх замаар хэрэгжилтийг хангуулан ажилласан. Үүнд: 1. 2025.01.17-нд Ойн газрын 6 төрлийн үйлчилгээ нэвтрүүлэлт 2. 2025.01.22-нд Монголбанкны албан бичиг солилцооны дундын системд холболт 3. 2025.02.07-нд Монгол Улсын Шинжлэх ухааны академийн “Үндэсний мэдлэгийн дата төв”-д шаардлагатай серверийн техникийн үзүүлэлтийн дагуу зохиомол серверийг Үндэсний дата төвд тохируулах 4. 2025.02.10-нд Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт ERP системд эрх олгуулах	2025.01.01-2025.06.15	100%

					5. 2025.02.24-нд Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа иргэдэд олгож буй лавлагаа, тодорхойлолтыг "солонгос хэл"-ээр гаргах 6. 2025.02.24-нд Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны төрийн үйлчилгээний ХУРДАН киоск машиныг шинэчлэх 7. 2025.02.26-нд Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийг нээх 8. 2025.02.27-нд Монгол Улсад гадаад хүнийг ажиллуулах виз мэдүүлэхээс өмнөх хүсэлт хүлээн авч шийдвэрлэх Боловсролын яамны үйлчилгээ нэвтрүүлэлт 9. 2025.02.27-нд Хил хамгаалах ерөнхий газрын "Ухаалаг цахим гарц"-ын программ хангамжийн сервис хөгжүүлэлт 10. 2025.03.07-нд Боловсролын зээлийн сангийн зээл, тэтгэлгийн гэрээ дүгнэх эргэн төлөлтийн хуваарь болон тус санд өр төлбөргүй тухай лавлагааны сервис хөгжүүлэлт 11. 2025.03.14-нд Шүүхийн тамгын газрын үндэсний болон албаны цахим шуудангийн холболт 12. 2025.04.03-нд Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн 5.0 хувилбарын шинэчлэлээр нэвтрүүлэх үйлчилгээний жагсаалт 13. 2025.04.03-нд суурь мэдээллийн сан, түүний нөөц, бусад мэдээллийн сангийн нөөцийг Үндэсний дата төвд байршуулах 14. 2025.04.18-нд "Грандмед" эмнэлгийн "Шинжилгээний хариу" цэсийн тохиргоо 15. 2025.04.25-нд spellcheck.gov.mn системд шинэчлэлт, сайжруулалт хийх 16. 2025.05.09-нд ХУРДАН, ДӨТ киоск машины үйл ажиллагааг нэгтгэх		
--	--	--	--	--	---	--	--

					17. 2025.05.20-нд Өргөдөл гомдлын системийн API сервис хөгжүүлэлт 18. 2025.05.23-нд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн харьяа 40 байгууллагын ашиглаж буй ERP системийн API сервис хөгжүүлэлт		
6.	Арга хэмжээ 2.4. Монгол Улсын “Эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)”-г Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, батлуулна.	Батлуулсан баримт бичгийн тоо	-	1	- Монгол Улсын Засгийн газрын 2024.07.24-ний өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хүрээнд эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийг үргэлжлүүлэн, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, Монгол Улсын “Цахим эрүүл мэнд”-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагч нарын дунд зохион байгуулсан. Үүнтэй холбогдуулан 2025 оны 03/03 тоот бичгийг Эрүүл мэндийн яаманд, 03/07 тоот бичгийг оролцогч байгууллагуудад, 03/24 тоот бичгийг УТҮГ-уудад, 02/749 тоот бичгийг И Монгол академи УТҮГ-т тус тус хүргүүлж, урьдчилсан бэлтгэл ажлыг хангасан. - Хэлэлцүүлгийн үр дүнд “Монгол Улсын эрүүл мэндийн салбарын дижитал шилжилтийн цогц арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн яамтай хамран эцэслэн боловсруулж, Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан 2025.05.24-ний өдрийн А/201 А/81 дугаар тушаалаар батлуулсан. Хэлэлцүүлэг, уулзалтын тайланг нэгтгэн боловсруулж, оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348 тоот бичгээр хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.15	100%

					- Түүнчлэн Эрүүл мэндийн сайдын 2025.02.28-ны өдрийн А/64 дүгээр тушаалын байгуулагдсан халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах “Эрүүл Монгол Хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө (2025-2028)-ний төслийг боловсруулах ажлын хэсэгт томилогдон ажиллаж, холбогдох санал, мэдээллийг боловсруулан өгсөн. - Эрүүл мэндийн сайдын 2025.04.02-ны өдрийн А/105 дугаар тушаалаар эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын төлөвшлийн үнэлгээг хийх Дэлхийн банкны техникийн багт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт томилогдон ажиллаж, “Эрүүл мэндийн салбарын кибер аюулгүй байдлын үнэлгээ” хийх судалгааг салбарын хэмжээнд авахад дэмжлэг үзүүлэн ажилласан.		
Зорилт 3. Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөлт хийх, мэргэжил, арга зүй, технологийн шийдэл, удирдлагаар хангах							
7.	Арга хэмжээ 3.1. Яамны төлөвлөгөөний 53. Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программын нэгж лицензийн үнийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программын нэгж лицензийн үнийг бууруулахад чиглэсэн ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах 2025.01.20-ны өдрийн 01/128 тоот бичгийг ЗГХЭГ, ШСАА, ТЕГ, ТХААГ, Нийтийн төв, ҮДТ-д хүргүүлсэн. Улмаар ажлын хэсгийг ЦХИХХСайдын 2025.02.12-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Үүнд: Нөхцөл байдлын судалгаа авах талаарх 2025.01.22-ны өдрийн 01/153 тоот бичгийг мэдээлэл хариуцагч 60 гаруй байгууллагад хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 5,671 байгууллагын 17% буюу 939 байгууллага судалгаанд	2025.01.01-2025.06.15	90%

	зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.				хамрагдсан бөгөөд 49,017 компьютер ашиглаж байгаагийн 88.5% нь, мөн 2,261 сервер ашиглаж байгаагийн 79% нь тус тус Майкрософтын корпорацийн бүтээгдэхүүнийг сонгон ашиглаж байна. Түүнчлэн төсвийн 68 байгууллагаас сүүлийн 2 жилийн хугацаанд Майкрософтын 6 төрлийн 138,164 ширхэг лицензийг нийт 5.5 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна. ▪ Кибер аюулгүй байдлын зөвлөлтэй хамтран Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яамаар дамжуулан Майкрософт корпорацийн Казакстан, Болгар, Румын, Египет, Турк Улсад байрладаг бүс нутгийг хариуцсан төвүүдийн мэргэжилтнүүдтэй холбогдон ажиллаж, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангах, бүх өгөгдлийг МУ-ын нутаг дэвсгэр дээр хадгалах шийдэл, оюуны өмчийн зөрчилгүй программ хангамж ашиглах, хамтран ажиллах талаар зөвлөлдсөн. Майкрософт корпораци МУЗГ-ын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шийдэл санал болгохоор урьдчилсан байдлаар хүлээн зөвшөөрсөн. ▪ Ажлын хэсгийн 2025.05.13-ны өдрийн хурлаар Майкрософт корпорацийтай цахим уулзалт хийж, харилцан ойлголцлын санамж бичгийн болон нууцлалын гэрээний төслийг эцэслэн боловсруулсан. ▪ Лицензийг нэгдсэн зохион байгуулалттайгаар “Цахим дэлгүүр”-т байршуулахад шаардлагатай техникийн тодорхойлолт хамтран боловсруулах 2025.03.21-ний өдрийн 03/632 тоот бичгийг ҮДТ-д хүргүүлэн хамтран ажилласан. Улмаар 2025.05.12-ны өдрийн байдлаар ТХААГ-тай хамтран 12 төрлийн лицензийг	
--	---	--	--	--	--	--

					ерөнхий гэрээгээр худалдан авах боломжийг бүрдүүлсэн. Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2025.05.28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулагдсан.		
Зорилт 4. Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах							
8.	Арга хэмжээ 4.1. Яамны төлөвлөгөөний 61. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв /11-11/ болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, мэдээллийн системийг нэгтгэх асуудлыг судалж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Иргэд, олон нийттэй харилцах төв "11-11"-ийн мэдээллийн системийг мэдэгдэл хүргэх системтэй холбож, улмаар иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд мэдэгдэл хүргэдэг болсон. - Засгийн газрын "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-д 11-11, 101, 102, 103, 105 дугааруудад ирүүлсэн дуудлага, түүний төрөл, шийдвэрлэлтийн статистик мэдээллийг "дашбоард" хэлбэрээр харах боломжийг бүрдүүлсэн. - Иргэдийн асуултад хариулах, хууль эрх зүйн зөвлөмж өгөх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг мэдээлэх чадвартай хиймэл оюунд суурилсан "IVA" системийг "11-11.mn" веб хуудсанд холбож, "Харилцагчийн үйлчилгээний хиймэл оюуны виртуал ажилтан, операторын үйлчилгээ"-г 2025.03.31-ний өдөр ЗГХЭГ-тай хамтран нэвтрүүлсэн. Тус хиймэл оюун нь 2025.05.29-ны байдлаар 51,099 үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс 13,944 нь өргөдөл, гомдол бүртгэгдсэний 4,791 буюу	2025.01.01-2025.06.15	100%

					34%-ийг хүний оролцоогүй шийдвэрлээд байна. - Засгийн газрын “11-11”, нийслэлийн “1800-1200” дугаарын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, системийг нэгтгэх шийдлийг боловсруулж, “API” сервисийн хөгжүүлэлт хийх чиглэлийг 2025 оны 02/1204 бичгээр И Монгол академид хүргүүлэн, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн. Үүнтэй холбогдуулан ЗГХЭГ, НЗДТГ, Иргэд олон нийттэй харилцах төв, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв, И Монгол академи УТҮГ, ERP систем хөгжүүлэгч байгууллагууд болон тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагуудтай нийт 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, ажлын хэсэг байгуулах төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Улмаар ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025.05.27-ны өдрийн 175 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, III дугаар улиралд багтаан дуусгах үүргийг өгсөн. Мөн Тус “11-11” төвд иргэдийн гадаад улсаас хийх дуудлагыг хүлээх авах боломжийг судалж, холбогдох саналыг 2025 оны 01/613 тоот бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. - Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2025.05.28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулагдсан.		
9.	Арга хэмжээ 4.2. Яамны төлөвлөгөөний 65.	Нэвтрүүлсэн хувилбар	2.0	3.0	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/01 дүгээр	2025.01.01-2025.06.15	70%

	Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлнэ.				тушаалын хүрээнд "Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 3.0 хувилбарыг нэвтрүүлэх" үйлчилгээний ажлын даалгаварт тусгах санал авах 2025.02.28-ны өдрийн 03/519 тоот бичгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Үндэсний дата төв УТҮГ-т хүргүүлж, ирүүлсэн хариуг нэгтгэн боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан. Тус ажлын даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/88 дугаар тушаалаар батлуулагдсан үнэлгээний хороонд шилжүүлсэн бөгөөд 2025.05.29-ний өдөр ЦХИХХЯ/20250103045 дугаартай тендерийг нээгээд байна. - Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 208 дугаар тогтоолын хүрээнд төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (gov.mn)-ыг сайжруулж, нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-тэй уялдуулах талаарх 2025.02.28-ны өдрийн 01/502 тоот бичгийг И-Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн. Улмаар И Монгол академи УТҮГ, систем хөгжүүлэгч "Аствишн" ХХК-тай 5 удаагийн уулзалтад оролцож /2025.03.18, 03.25, 04.24, 05.29, 06.05/, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. - Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны "Штаб шинэчлэн байгуулах тухай" А/46 дугаар тушаалын хүрээнд Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран "shilen.gov.mn"-д нийт 4,126 байгууллагын 4,134 албан хаагчдад системийн хандах эрхийг олгож, 2,794 албан хаагчдыг сургалтад хамруулаад байна.		
--	--	--	--	--	---	--	--

10.	Арга хэмжээ 4.3. Эрүүл мэндийн тухай хуулийн 8.10 дахь хэсэгт заасан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам”-ыг Эрүүл мэндийн яамтай хамтран боловсруулж, батлуулна.	Батлуулсан баримт бичгийн тоо	-	1	- Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсэгт заасан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлагыг тогтоох, үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам” батлах хамтарсан тушаалын төсөлд санал авах 2025.03.21-ний өдрийн 03/631 тоот бичгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон харьяа УТҮГ-т хүргүүлэн, харьяа байгууллагуудын хариуцсан албан хаагч нартай хамтран боловсруулж, 2025.03.25-ны өдрийн 01/655 бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Тус журмын төслийг 2025.04.10, 11-ний өдөр салбар дундын хамтарсан хурлаар хэлэлцүүлэн, улмаар ЭМС, ЦХИХХС-ын хамтарсан 2025.04.16-ны өдрийн А/130 А/58 тушаалаар батлуулсан. 2025.04.21-ний өдрийн 2/1957 (ЭМЯ)-ны бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлж, 2025.05.13-ны өдөр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. - Тус журмыг хэрэгжүүлэх Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын хамтарсан 2024.12.31-ний өдрийн А/541 А/76 дугаар тушаалаар байгуулагдсан байнгын ажиллагаатай ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж байна. - Түүнчлэн эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санд холбогдож, мэдээлэл нийлүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа мэдээллийн систем хөгжүүлэгч байгууллагад 2025.01.01-ний өдрөөс 12.31-ний өдрийг дуусталх хугацаанд Үдсэн систем “ХУР”-ыг төлбөргүй байдлаар ашиглуулахаар шийдвэрлүүлж, 2025.02.24-	2025.01.01-2025.06.15	100%
-----	--	-------------------------------	---	---	---	-----------------------	------

					ний өдрийн 03/346 тоот бичгийг Үндэсний дата төв УТҮГ-т хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулсан. ■ Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2025.05.28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулагдсан.		
Зорилт 5. Цахим орчинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөв зохистой хэрэглээний соёлыг нэвтрүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулах, иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх							
11.	Арга хэмжээ 5.1. Яамны төлөвлөгөөний 55. Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгоно.	Батлагдсан ажлын даалгаврын тоо	-	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/01 дүгээр тушаалын хүрээнд “Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгох” үйлчилгээний ажлын даалгаварт тусгах санал авах 2025.02.27-ны өдрийн 03/483 тоот бичгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, харьяа УТҮГ-уудад хүргүүлж, ирүүлсэн хариуг нэгтгэн боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан.	2025.01.01-2025.03.31	100%
		Системийн тоо	-	-	“Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгох” үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны тушаалын төслийг боловсруулан, Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.14-ний өдрийн А/89 дугаар тушаалаар батлуулсан. Тус тушаалаар томилогдсон үнэлгээний хороо ажиллаж, 2025.05.29-ний	2025.01.01-2025.06.15	- /II хагас жилд/

					өдөр ЦХИХХЯ/20250103041 дугаартай худалдан авах ажиллагааг нээгээд байна.		
ХОЁР. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
12.	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнана.	Батлагдсан төлөвлөгөөний тоо	-	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, 2025 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр батлуулсан.	2025.01.01-2025.01.08	100%
		Тайлангийн тоо	-	1	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн 2025 оны эхний хагас жилийн тайланг боловсруулж, заасан хугацаанд Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.15	100%
13.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана.	Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	1	Хэрэгжил тээр	Боловсруулсан албан бичгийн төслийг бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнд, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тушаалын төслийг хуулийн мэргэжилтэнд, тайлан, түүний холбогдох баримтыг тайлан хариуцсан мэргэжилтэнд тус тус тухай бүр хүлээлгэн өгч ажилласан. Төрийн албан зөвлөлийн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Салбар зөвлөлийн 2023, 2024 он, 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны баримт бичгүүдийн архивыг бэлтгэж, хүлээлгэн өгсөн.	2025.01.01-2025.06.15	100%
14.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо	6	Хэрэгжил тээр	Төрийн үйлчилгээний нэгдсэн системд Монгол Банкнаас зарласан ханшийн лавлагааг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр И-Монгол академи УТҮГ-тай хамтран нэвтрүүлж, G250115001 дугаартай иргэний гомдлыг шийдвэрлэсэн.	2025.01.01-2025.06.15	100%

	өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ						
15.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.	ХАСХОМ бөглөх болон хуулийн хэрэгжилтийг хангаж, ажилласан баримтын тоо	5	6	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр буюу хуульд заасан хугацаанд багтаан мэдүүлсэн.	2025.01.01-2025.02.10	100%
16.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ.	Өгсөн үүрэг даалгаврын тоо	-	Хэрэгжил тээр	- Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж болон салбарын тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээг тус яам зохион байгуулах санал, дэмжлэг хүссэн бичгийг 2025.01.07-ны өдрийн 01/21, 01/31 тоот тус тус бичгээр Шадар сайдад хүргүүлсэн. “Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаж, саналаа 2025.01.30-ны өдрийн 01/212 тоот албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. - МУ-ын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Дронокон-2025” нисгэгчгүй нисэх төхөөрөмж жолоодлогын улсын аварга шалгаруулах анхдугаар тэмцээн	2025.01.01-2025.06.15	100%

				2025.01.25,26-ны өдрүүдэд зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэв. 4. Цахим орчин дахь аюулгүй байдал, хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх УИХ-ын гишүүн О.Номинчимэгийн асуулгатай танилцаж, “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-ын чиглэлээр хийсэн ажлын тайланг нэгтгэн, 2025.02.07-ны өдрийн 01/313 тоот албан бичгээр хүргүүлсэн. 5. “Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлтэй танилцаж, холбогдох саналаа 2025.02.12-ны өдөр цахим шуудангаар тус яамны ХШҮДАГазарт хүргүүлэв. 6. ЗГХЭГ-аас ХЭГ/499 тоот бичгээр ирүүлсэн “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалтай танилцаж, холбогдох саналаа 2025.02.19-ний өдрийн 01/404 тоот бичгээр хүргүүлсэн. 7. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар ЭМС-ын 1а/315 бичгээр хүсэлтийг 2025.02.24-ны өдөр цахим шуудангаар тус яамны СБТГ-т хүргүүлсэн. 8. Эрүүл мэндийн цахим шилжилтийн чиглэлээр тус яамнаас хийсэн ажлын хэрэгжилттэй ЕТГ-аас 2025.03.27-ны өдөр танилцах хүрээнд холбогдох бэлтгэл ажлыг хангасан. 9. Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн нөөцийг ҮДТ-д байршуулан, их өгөгдөлд тулгуурлан мэдээллийг урьдчилан тооцоолох нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 2025.03.14-ны өдөр НДЕГ-тай уулзалт		
--	--	--	--	---	--	--

					зохион байгуулж, холбогдох саналыг 2025.04.02-ны өдрийн 01/711 бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлсэн. 10. УОК-ын салбар дундын мэдээллийн систем хөгжүүлэх ажлын хүрээнд “Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем”-д статистик холболт хийх ажлыг ЗГХЭГ, холбогдох УТҮГ-тай хамтран хийж, тайланг 2025.02.18-ны өдөр 03/384 бичгээр мөн тус системийн хөгжүүлэлтийг 2025.09.01-ний өдрөөс эхлэх талаар 2025.04.25-ны өдрийн 02/960 бичгээр УОК-ын ажлын албанд хүргүүлсэн. 11. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэх “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай” тогтоолын төсөлтэй танилцаж, холбогдох саналаа 2025.05.09-ний өдрийн 01/1101 тоот бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 52 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээллийг нэгтгэн боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2025 оны 05 дугаар сарын 28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулагдсан. Үүнтэй холбогдуулан төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 4,119 байгууллагын 2000 оноос хойших биет бус хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн 13,526 программ хангамжийн судалгааг Төрийн	2025.05.19 2025.05.28	100%

	Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.				өмчийн бодлого зохицуулалтын газраас, 2012-2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 22 төсөл, 2025 онд хэрэгжиж байгаа 2 төсөл болон Засгийн газрын гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр 2015-2024 онд хэрэгжсэн 2 төсөл, 2025 онд хэрэгжиж 8 төслийн мэдээллийг 2025.04.17-ны өдрийн 02/3005 дугаар албан бичгээр Сангийн яамнаас авч нэгтэн боловсруулж, 2024.04.24-ний өдрийн 01/954 тоот албан бичгээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлсэн.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 214 дүгээр тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэнэ.	Үйл ажиллагаа ны тоо	-	3	- Салбар зөвлөлийн 2025.04.28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор байгуулагдсан шалгалтын комиссын нарийн бичгийн даргаар ажиллаж, тус яамны гүйцэтгэх 12 албан тушаалын 52 оролцогчтой тусгай шалгалтыг 2025.05.06-ны өдөр “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ыг баримталж төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг зохион байгуулан. тайланг хугацаанд нь хүргүүлсэн. - Төрийн албаны зөвлөлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлд харьяалах байгууллагуудын судалгааг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр, төрийн албаны 30 жилийн ойн номын материалыг нэгтгэн, 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Төрийн албаны зөвлөлд цахим шуудангаар хүргүүлсэн. - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай” 213 дугаар тогтоолыг шинэчлэн боловсруулж, батлуулах хүсэлтийг 2025.05.23-ны өдрийн 01/1264, 2025.05.30-ны өдрийн 01/1325 бичгээр тус тус	2025.04.28 2025.12.31	100%

					Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.		
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Монгол Улсын суурь мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулж, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр Улсын бүртгэлийн газартай байгуулсан 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	Үйл ажиллагаа ны тоо	-	10	Суурь мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 13 саналыг боловсруулж, 2025.02.28-ны 01/514 тоот бичгээр УБЕГ-т хүргүүлсэн. Тус саналын дагуу ЦХИХХСайд болон УБЕГ-ын дарга нарын санал солилцох уулзалтыг 2025.03.11-ний өдөр зохион байгуулж, улмаар 2025.03.20-ны өдөр хамтран ажиллах төлөвлөгөөг батлуулсан. Үүнд: - Төрийн үйлчилгээний нэгдсэн системд 3 төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх талаар 2025.04.03-нд 01/729 тоот бичгээр И Монгол академид чиглэл хүргүүлсэн ба нэвтрүүлэлтийг 5.0 хувилбар гаргахаар ажиллаж байна. - Төрийн үйлчилгээний “ХУРДАН”, “ДӨТ” зэрэг киоскийн үйл ажиллагааг нэгтгэх ажлыг зохион байгуулах талаар 2025.05.09-ны өдрийн 01/1114 тоот бичгээр ТЦҮЗГ-т хүргүүлсэн. Тус агентлагаас төрийн 52 байгууллагын 279 киоск машин ажиллуулж байгаа судалгааг авч, нэгтгэх ажлыг зохион байгуулж байна. - Хуулийн этгээдийн нэрийн давхардлыг шалгадаг хиймэл оюуны систем нэвтрүүлэх болон гамшгийн үед бүртгэлийн үйлчилгээнд ашиглах автомашиныг мэдээллийн технологийн тоног төхөөрөмжөөр тоноглох ажлын даалгаврыг боловсруулсан. - Бүртгэлийн үйлчилгээнд төлбөрийн хэрэгслийн сонголтод хувилбарыг бий болгох талаарх 2025.03.12-ны өдрийн 01/573 тоот бичгийг Сангийн сайдад хүргүүлсэн. Үүнтэй холбогдуулан 2025.04.22-ны өдөр ЦХИХХЯ, Сангийн яам, УБЕГ, ТЦҮЗГ, И Монгол академийн хэмжээнд уулзалт зохион байгуулж, интеграци хийх зааврыг 2025.04.29-ны өдөр УБЕГ-т	2025.03.20 2025.12.31	80%

					хүргүүлсэн. - Хууль хяналтын байгууллагуудад цахим лавлагаа, тодорхойлолтыг хүлээн зөвшөөрүүлэх, цахим хэлбэрээр солилцох хүрээнд УБЕГ-тай хамтран УДШ, ШЕЗ, ШШЕГ, ЦЕГ-тай 2025.04.29, 30-ний өдрүүдэд уулзалт зохион байгуулсан. - ТЦҮЗГ-ын даргын 2025.03.17-ны өдрийн А/15 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, үндсэн систем “ХУР”-д сервисийн тасалдал, саатал үүсэхэд мэдэгдэл хүргэх журмын төслийг боловсруулсан. - УБЕГ-тай 2025.04.21-ний өдөр уулзалт зохион байгуулж, бүртгэлийн 3 төрлийн гэрчилгээнд блокчейн технологи нэвтрүүлэхээр тогтож, ажлын даалгаварт тусган, холбогдох үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. - Улсын бүртгэлийн “opendata.burtgel.gov.mn” систем, төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал “opendata.gov.mn” хооронд “Нээлттэй өгөгдлийн жагсаалт” дахь 19 төрлийн нээлттэй өгөгдлийг шууд холбож, 2025.05.15-ны өдрийн байдлаар ашиглалтад бүрэн оруулсан. - Суурь мэдээллийн сан, түүний нөөцийг Үндэсний Дата төвд шилжүүлэн байршуулах чиглэлийг 2025.04.03-нд 01/732 тоот бичгээр ҮДТ-д чиглэл хүргүүлсэн. - Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2025.05.28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулагдсан.		
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. НҮБ-ын Хүүхдийн сан болон	Үйл ажиллагаа ны тоо	-	3	ЦХИХХС-ын 2025.04.15-ны өдрийн А/57 тоот тушаалыг боловсруулан батлуулж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан болон Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажиллах, холбогдох	2025.04.15 2025.12.01	80%

	Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажиллах, холбогдох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, НҮБ-ын санхүүжилтэй "Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC)" төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.				төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Үүнд: ■ Монгол Улсын Засгийн газар – НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтран хэрэгжүүлэх улс орны хөтөлбөрийн 2024-2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд 2025.03.18, 27-ны өдөр буюу нийт 2 удаагийн техникийн уулзалтыг НҮБ-ын Хүүхдийн Сантай хийж, нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан, 6 зорилтын дагуу 8 үйл ажиллагааг эхлүүлэх талаарх санал, санхүүжилтийн тооцооллыг боловсруулан, 2025.05.14-ний өдөр цахим шуудангаар Хүүхдийн Санд хүргүүлсэн. ■ Монгол Улсын "Цахим эрүүл мэнд"-ийн цогц арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г хэлэлцэх уулзалт, хэлэлцүүлгийг НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр 2025.04.10, 11-ний өдрүүдэд 20 байгууллагын 52 албан хаагч нарын дунд зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнгийн тайланг нэгтгэн боловсруулж, оролцогч 20 байгууллагад 2025.06.05-ны өдрийн 02/1348 тоот бичгээр хүргүүлсэн. ■ Байгалийн гамшигт үзэгдэл, осол аваар, нийтийг хамарсан гамшгийн үед болон нүүлгэн шилжүүлэлт, хоргодох байр, аврах ажиллагаа зэрэгт хамрагдсан иргэдэд газар дээр нь шуурхай лавлагаа, улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бичиг баримтын баталгаажуулалт хийхэд шаардлагатай хөдөлгөөнт үйлчилгээний тусгай зориулалтын автомашиныг мэдээллийн технологийн тоног төхөөрөмжөөр тоноглох ажлын даалгаврыг боловсруулан, 2025.05.15-ны өдөр ЦХИХХЯ, ОБЕГ, УБЕГ, НҮБ-ын Хүүхдийн Сан хамтарсан цахим уулзалтыг зохион байгуулсан ба 2025.06.04-ний өдрийн 02/1347 тоот дэмжлэг хүссэн бичгийг Хүүхдийн санд хүргүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--

					▪ DEMOSC төслийн хүрээнд 2025.04.24-ний өдөр Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан төслийн хаалтын үйл ажиллагаа болон 2025.05.01-ний өдөр эрүүл мэндийн салбарын ажилтнуудад цахим ур чадварын сургалтыг Эрүүл мэндийн яаманд дээр зохион байгуулахад тус тус дэмжлэг үзүүлэн ажилласан. ▪ НҮБ-ын Хүүхдийн Сангийн дунд хугацааны үнэлгээний хуралд 2025 оны 05 сарын 01-ний өдөр оролцож, холбох санал хүсэлтээ хэлсэн.		
5.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Google компани өөрсдийн платформ дээрх системүүдийн бүртгэлийг шинэчилж байгаатай холбогдуулан олон улсын "DUNS" дугаарлалтын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулалт хийсэн ажлын тоо	-	1	▪ "DUNS" дугаартай холбоотой хүсэлт хүлээн авах сошиал холбоосыг тогтмол ажиллуулж, тус яаманд хүсэлт ирүүлсэн 300 гаруй байгууллагын жагсаалтыг 2025.01.02-ны өдөр Google төлөөлөгчид /temuulen@mddic.gov.mn/ цахим шуудангаар хүргүүлэн, холбогдох заавар мэдээллээр ханган ажилласан. ▪ "Google app store" дээрх developer бүртгэл "DUNS" дугааргүйн улмаас апп нь устгагдах эрсдэлд орсон аж ахуйн нэгж, байгууллагууд хүсэлтээ шууд Google компани руу шууд илгээдэг болсон бөгөөд мэдээллийг 2025.01.06-ны өдөр нийт албан хаагчдад болон яамны нийгмийн сүлжээгээр дамжуулан олон нийтэд мэдээлсэн. ▪ Монгол Улсын аж ахуйн нэгжүүдэд тулгамдсан тус асуудлаар АНУ-ын Элчин сайдын яам, ЦХИХХЯ, Гүүгл компанийн хамтарсан цахим уулзалтыг 2025.03.19-ны өдөр Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Улмаар Гүүгл Клауд системийн текстээс яриа, ярианаас текст рүү хөрвүүлэгч сервисүүдэд монгол хэлийг нэмэх, холбогдох технологийн боломжийг судлах, DUNS дугаарын асуудлыг шийдвэрлэх талаарх 2024 оны MDDIC/01/81, 2025 оны MDDIC/01/29	2025.01.02 2025.12.31	100%

					тоот албан бичгийг Гүүгл компанид хүргүүлээд байна. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран “DUNS” дугаарын асуудал үүссэн 314 аж ахуйн нэгжүүдтэй холбогдож бүртгэлийг шалгахад 2025.06.01-ний өдрийн байдлаар “Google play store” дээрх бүртгэл амжилттай 197, амжилтгүй 62, аппликэйшн устсан 4, шинээр бүртгүүлэх 7, тодорхойгүй байгаа 44 байгууллагын судалгааг гаргаж, Гүүгл компанид албан мэйл хүргүүлээд байна.		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
				4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Эрхэлсэн ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох	Олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцсон тоо	3	4	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025.01.23-ны өдрийн А/07 дугаар тушаалаар Тайландын Хаант Улсын Бангкок хотноо 2025 оны 01 дүгээр сарын 27-оос 02 дугаар сарын 03-ны өдрүүд “PMAC 2025” чуулга уулзалтад дижитал эрүүл мэндийн талаар туршлага хуваалцахаар томилогдон ажилласан. Тус чуулга уулзалтын 2 дахь өдөр буюу 2025.01.29-ны өдөр “Convergence Workshop-арга зүйгээр дамжуулан үндэсний дижитал	2025.01.01-2025.06.15	100%

					эрүүл мэндийн төлөвлөлт, архитектур, чадавхыг бэхжүүлэх” сэдвийн хүрээнд тус яамнаас хэрэгжүүлсэн эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн ажлын үр дүнг танилцуулж, хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлсэн сэдвийн хүрээнд оролцогч талуудыг бүрэн хамарсан байдал, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, Засгийн газрын манлайлал зэрэг үйл ажиллагааг бусад улсын оролцогч нараас онцлон сайшаасан.		
2.	Арга хэмжээ 2. Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох	Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцсон тоо	-	1	Дотоодод зохион байгуулагдсан дараах сургалт, хурал, семинарт оролцсон. Үүнд: ■ 2025.01.06-ны өдөр "Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны хөгжлийн чиг хандлага" сэдэвт сургалт; ■ 2025.02.13-ны өдөр Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн анхдугаар хэлэлцүүлэг; ■ 2025.02.19-ны өдөр Монгол Улсын Кибер аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний тайлангийн хурал.	2025.01.01- 2025.06.15	100%

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

САЛБАР ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ
ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ

(Албан тушаал)

Г.ЭНХТУЛГА /  /

(Нэр, гарын үсэг)

.....

(Огноо)

—oOo—